



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 сарын 24 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:


“4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

4.1. Энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 сарын 24 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2¹ дүгээр зүйл:

"2¹ дүгээр зүйл. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр

2¹.1. Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална."

2/6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалт:

"6.1.14 энэ хуулийн 2¹ дүгээр зүйлд заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах."

3/30 дугаар зүйлийн 30.9, 30.10 дахь хэсэг:

30.9. Авлигатай тэмцэх газарт гүйцэтгэх ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажилласан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд тооцно.

30.10. Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтан тусгай ажиллагаанд оролцохдоо байгууллагын бэлгэ тэмдэг бүхий зориулалтын хувцас хэрэглэх бөгөөд уг хувцасны загварыг Авлигатай тэмцэх газрын дарга батална."

2 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалтын "шат дамжлагыг цөөрүүлэх" гэсний дараа " , энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;" гэж, мөн зүйлийн 6.6 дахь хэсгийн "шийдвэрийг" гэсний өмнө "хууль ёсны шаардлага," гэж, "байгууллага" гэсний дараа " , албан тушаалтан," гэж, 13 дугаар зүйлийн 13.8.3 дахь заалтын "бууруулах" гэсний дараа " , эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах" гэж, 18 дугаар зүйлийн 18.4.11 дэх заалтын "шилжүүлэх" гэсний дараа " , энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх" гэж, 18.4.15 дахь заалтын "хяналт тавих," гэсний дараа "шалгах," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйл:

“4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

4.1.1.төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

4.1.2.төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

4.1.4.олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

4.1.5.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

4.1.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

4.1.7.бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

4.1.8.эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан.”

2/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:

“10.2.Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.”

3/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

 “10.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ.”

4 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13 дахь заалтын “дэмжих.” гэснийг “дэмжих,” гэж, 13 дугаар зүйлийн 13.8.1, 13.8.2 дахь заалтын “цалинтай” гэснийг “цалин хөлстэй” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтын “55” гэснийг “45” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.